

# НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Налайх авто зам засвар, арчлалт ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2024/99/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2024 он	Баталгаат тооцоолол аудит ХХК, захирал М.Буянбулган Утас: 77153069 Цахим хаяг: buyanbulgan@batalgaattaudit.com Аудитын менежер: Г.Цогтбаатар Цахим хаяг: tsogtbaatar@batalgaattaudit.com Ахлах аудитор: Н.Цэнгэнбаяр Цахим хаяг: tsengenbayar.n@batalgaattaudit.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15 № 580  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НАЛАЙХ АВТО ЗАМ ЗАСВАР  
АРЧЛАЛТ ТӨХК-ИЙН ЗАХИРАЛ  
Ц.БАТТУЛГА ТАНАА

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Налайх авто зам засвар арчлалт ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн орлого, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Налайх авто зам засвар арчлалт ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар бүх явцыг санхүүгийн тайланд толилуулж, толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

### Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт, хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тайлант оны захирлын гэрээний үүргийн хэрэгжилтийг аудитын тайлангийн дүгнэлтийг харгалзан үзэж дүгнэдэг байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх үеийн тайлан	Тайлант хугацаа
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	28,166,885.57	9,876,951.58
1.1.2	Дансны авлага	302,940,391.93	55,282,520.07
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.00	10,965,691.27
1.1.4	Бусад авлага	62,919,677.22	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		-
1.1.6	Бараа материал	253,614,786.18	80,079,809.52
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	100,874,495.00	-
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>748,516,235.90</b>	<b>156,204,972.44</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,815,722,300.18</b>	<b>2,761,749,054.40</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,564,238,536.08</b>	<b>2,917,954,026.84</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>2.2</b>	<b>ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН</b>	<b>1,209,990,927.92</b>	<b>1,016,165,786.99</b>
<b>2.3</b>	<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>862,884,484.18</b>	<b>862,884,484.18</b>
2.3.1	Өмч: а) төрийн	<b>862,884,484.18</b>	<b>862,884,484.18</b>
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,980,538,880.85	1,980,538,880.85
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(489,175,756.87)	(941,635,125.18)
<b>2.3.11</b>	<b>ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,354,247,608.16</b>	<b>1,901,788,239.85</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,564,238,536.08</b>	<b>2,917,954,026.84</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх үеийн тайлан	Тайлант хугацаа
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>1,671,571,890.54</b>	<b>3,014,513,527.81</b>
2	Борлуулалтын өртөг	1,435,116,852.40	3,045,729,836.84
<b>3</b>	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>236,455,038.14</b>	<b>(31,216,309.03)</b>
8	Бусад орлого		431,715.25
9	Борлуулалт, маркетингийн зардал		46,471,267.78
10	Ерөнхий ба удирдлагын зардал	40,406,318.50	312,283,829.53
11	Санхүүгийн зардал	273,989,361.72	
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )</b>	<b>(77,940,642.08)</b>	<b>(389,539,691.09)</b>
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг ( алдагдал )</b>	<b>(77,940,642.08)</b>	<b>(389,539,691.09)</b>
<b>21</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг ( алдагдал )</b>		
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</b>	<b>(77,940,642.08)</b>	<b>(389,539,691.09)</b>
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(77,940,642.08)</b>	<b>(389,539,691.09)</b>
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг ( алдагдал )</b>		

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
---	----------	-----	-----------------	--------------------	----------

Налайх Авто зам засвар, арчлалт ТӨХК-ийн  
2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

			үнэлгээний нэмэгдэл		
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,107,902,167.48	1,980,538,880.85	(411,235,114.79)	2,677,205,933.54
2	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(77,940,642.08)	(77,940,642.08)
6	Өмчид гарсан өөрчлөлт	(245,017,683.30)		-	(245,017,683.30)
9	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	862,884,484.18	1,980,538,880.85	(489,175,756.87)	2,354,247,608.16
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-		(62,919,677.22)	(62,919,677.22)
11	Залруулсан үлдэгдэл	862,884,484.18	1,980,538,880.85	(552,095,434.09)	2,291,327,930.94
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(389,539,691.09)	(389,539,691.09)
17	2023 оны 12 р сарын 31-ний үлдэгдэл	862,884,484.18	1,980,538,880.85	(941,635,125.18)	1,901,788,239.85

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх үеийн тайлан	Тайлант хугацаа
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>1,806,704,072.80</b>	<b>3,612,943,284.14</b>
1.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,796,911,384.00	3,122,086,629.23
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	9,792,688.80	
	Бусад мөнгөн орлого		490,856,654.91
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>1,802,264,851.01</b>	<b>3,561,651,933.38</b>
	Ажиллагчдад төлсөн	544,121,578.40	809,964,481.48
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	150,000,000.00	202,300,000.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	847,105,368.21	1,965,131,821.42
	Ашиглалтын зардалд төлсөн	568,250.00	9,538,862.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	166,827,887.77	371,109,830.00
	Хүүний төлбөрт төлсөн	772,640.91	622,876.36
	Татварын байгууллагад төлсөн	88,874,053.90	48,630,903.75
	<b>Бусад мөнгөн зарлага</b>	<b>3,995,071.82</b>	<b>154,353,158.37</b>
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>4,439,221.79</b>	<b>51,291,350.76</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		<b>431,715.25</b>
	Хүлээн авсан хүүгийн орлого		431,715.25
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	<b>431,715.25</b>
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>104,176,000.00</b>	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	<b>104,176,000.00</b>	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>85,140,000.00</b>	<b>70,013,000.00</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	85,140,000.00	70,013,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>19,036,000.00</b>	<b>(70,013,000.00)</b>
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	23,475,221.79	(18,289,933.99)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,691,663.78	28,166,885.57
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,166,885.57	9,876,951.58

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Налайх Авто зам засвар, арчлалт ТӨХК-ийн  
2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

№	Үзүүлэлтүүд	Х/нэгж	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	М/төг	2,068,818.17	3,014,957.20	(946,139.03)	146%
а	Зам засвар арчлалтын ажил	М/төг	1,363,636.36	1,504,790.60	(141,154.24)	110%
б	Машин механизмын орлого	М/төг	181,818.18	38,395.40	143,422.78	21%
в	Тохижилт болон бусад ажлын орлого	М/төг	335,181.82	1,406,284.20	(1,071,102.38)	420%
г	бусад орлого	М/төг	188,181.81	65,487.00	122,694.81	35%
2	Нийт орлого	М/төг	<b>2,068,818.17</b>	<b>3,014,957.20</b>	(946,139.03)	146%
3	Нийт зардал	М/төг	<b>2,065,854.10</b>	<b>3,404,496.89</b>	(1,338,642.79)	165%
4	Татвар төлөхийн өмнөх ашиг	М/төг	2,964.07	(389,539.69)	392,503.76	- 13142%
5	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>М/төг</b>	<b>2,667.66</b>	<b>(389,539.69)</b>	392,207.35	- 14602%
6	Төсвийн нийт төлбөр	М/төг	<b>386,567.76</b>	<b>456,666.40</b>	(70,098.64)	118%
	а.Орлогын албан татвар	М/төг	296.41	32.60	263.81	11%
	б.НӨАТ	М/төг	206,881.82	188,052.40	18,829.42	91%
	в.НДШ	М/төг	95,871.60	202,300.00	(106,428.40)	211%
	г.Хүн амын орлогын татвар	М/төг	57,416.64	44,262.70	13,153.94	77%
	д.Үл хөдлөх хөрөнгийн татвар	М/төг	23,101.30	22,051.30	1,050.00	95%
	е.Тээврийн хэрэгслийн татвар	М/төг	3,000.00		3,000.00	0%
ё.бусад татвар	М/төг			-		
7	Төрийн өмчийн ноогдол ашиг	М/төг	400.15	-	400.15	0%
8	Нийт ажиллагсадын тоо	хүн	42	40	2.00	95%
9	<b>Нийт цалингийн сан</b>	М/төг	<b>710,160.00</b>	<b>630,259.70</b>	79,900.30	89%
10	Нэг ажилтны дундаж цалин /1сарын/		1,280.20	1,313.00	(32.80)	103%
11	<b>Борлуулалтын орлогоос 1 төгрөгт ногдох зардал</b>	<b>М/төг</b>	<b>1.00</b>	<b>1.13</b>	(0.13)	113%
12	Хөрөнгө оруулалт	М/төг	<b>104,650.00</b>	-	104,650.00	0%
13	Нийт авлага	М/төг	71,700.00	66,248.20	5,451.80	92%
	Үүнээс: Найдваргүй		62,934.50	-	62,934.50	0%
14	Нийт өглөг	М/төг	825,474.90	1,016,165.80	(190,690.90)	123%
	Богино хугацаат өр төлбөр	М/төг	825,474.90	1,016,165.80	(190,690.90)	123%

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 16,240.8 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрч санхүүгийн тайланд залруулга хийлгэн, баталгаажуулж, нийт 25,133.3 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч 2 зөвлөмж өгсөн.

### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүү байдлын тайлангийн хөрөнгийн үлдэгдэл, үндсэн хөрөнгийн тодруулга тайлантай зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	16,240.8					1	16,240.8				
	1	16,240.8					1	16,240.8				

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТӨБЗГ-ын шийдвэрээр шилжин ирсэн зарим хуучин үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг үндэслэлтэй тогтоож бүртгэлд тусгаагүй.	1						1					
Дансны өглөгийг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй.	1	25,133.3					1	25,133.3				
Дүн	2	25,133.3					2	25,133.3				

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс		Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 3 мэдээллийг хугацаа хоцроосон, 12 мэдээллийг мэдээлээгүй.	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТУЗ-ийн дарга гишүүдийн хурлын ирц тэмдэглэл тодорхойгүй.	1	-					1	-
НӨАТ-ийн тайланд борлуулалтын орлогыг дутуу тайлагнасан	1	182,834.1					1	182,834.1
Бараа ажил үйлчилгээний худалдан авалтад хууль, журмыг мөрдлөг болгоогүй.	1	122,853.0					1	122,853.0
Дүн	3	305,687.1					3	305,687.1
Нийт дүн	4	305,687.1					4	305,687.1

### 5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТБОНӨҮГ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	1	1			1			